



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/01-НА-СТА-ОНА

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитор: Ч.Цэрэннадмид

Утас: 95112689 Цахим хаяг: [tsesb.audit@gmail.com](mailto:tsesb.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3-5
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	10
3.Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	12
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	13
4. Аудитын тайлан .....	14
4.1. Ерөнхий зүйл .....	14
4.2. Материаллаг байдал .....	15
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.3.1 Шилэн дансны мэдээлэл .....	15
4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. Аудитын илрүүлэлт .....	18
5.1 Залруулга .....	19
5.2 Төлбөрийн акт .....	20
5.3 Албан шаардлага .....	20
5.4 Зөвлөмж .....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	22
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл .....	22



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

“СЭЛЭНГЭ ЭНЕРГО”  
ОНӨААТҮГ-ЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.АЛТАНСҮХ  
ТАНАА

2023-03-15 № СЭА-2023/01-НА-СТА-ОНА  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн нөлөөг эс тооцвол “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар он дамжсан цалингийн урьдчилгааны авлага үүсгэсэн, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйлгээг гүйцэтгэсэн, үр ашиггүй зардлыг санхүүжүүлсэн, санхүүгийн тайланд тусгасан өр төлбөр нь тооцоо нийлсэн актаас зөрүүтэй илэрхийлэгдсэн, батлагдсан зардлыг хэтрүүлсэн зэрэг зөрчлүүд илэрсэн байна. Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дугаар заалтууд

СЭА-2023/01-НА-СТА-ОНА

болон аймгийн Засаг даргын баталсан “Сэлэнгэ Энерго ” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн орлого, зарлагын нэгдсэн төлөвлөгөө”-г тус тус зөрчсөн байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд ажил, үйлчилгээний нийт орлогыг 7,078,863.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 7,742,359.8 мянган төгрөг төвлөрүүлэн, төлөвлөгөөг 9.4 хувиар давуулан биелүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 8,654,057.1 мянган төгрөг болж төлөвлөснөөс 622,531.2 мянган төгрөг буюу 7.8 хувиар хэтэрсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 911,697.3 мянган төгрөг болж, төлөвлөгөөт алдагдлыг 40,965.7 мянган төгрөгөөр бууруулсан нь нийт орлогыг 9.4 хувиар давуулан биелүүлснээс шалтгаалсан байна.

### **Аудитын гол асуудал**

Тус үйлдвэрийн газар нь тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогоос 5,801,733.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 454,545.4 мянган төгрөгийн татаас, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 15,000.0 мянган төгрөг, Эрчим хүчний яамнаас 818,182.8 мянган төгрөгийн татаас санхүүжилт, эрчим хүчний хөнгөлөлтийн орлогоос 745,035.3 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 65,429.5 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

2022 оны санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан урсгал засварын зардлыг 132,930.0 мянган төгрөгөөр, нүүрс болон нүүрсний тээврийн зардлыг 235,673.0 мянган төгрөгөөр, сэлбэг хэрэгслийн зардлыг 66,694.0 мянган төгрөгөөр, байгууллагаас төлөх НДШ-ийн зардлыг 132,430.0 мянган төгрөгөөр, ашиглалтын зардлыг 186,686.0 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 4,229.0 мянган төгрөгөөр, хөдөлмөр хамгааллын зардлыг 26,693.0 мянган төгрөгөөр, бусад зардлыг 116,762.0 мянган төгрөгөөр зэрэг нийт **902,097.0** мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	14,376,166.72	10,561,149.98
1.1.2	Дансны авлага	1,588,484,086.78	1,452,169,894.84
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	41,411,377.14	
1.1.4	Бусад авлага		
1.1.6	Бараа материал	902,057,282.97	802,886,888.88
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,546,328,913.61</b>	<b>2,265,617,933.70</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	20,366,914,654.43	20,414,635,666.55
1.2.2	Биет бус хөрөнгө	570,047,660.20	568,520,400.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>20,936,962,314.63</b>	<b>20,983,156,066.55</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>23,483,291,228.24</b>	<b>23,248,774,000.25</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	4,783,550,229.29	3,622,540,493.41
2.1.1.3	Татварын өр	3,066,950,716.08	4,020,313,660.18
2.1.1.5	Богино хугацаат зээл	37,158,718.32	57,022,746.48
2.1.1.9	Богино хугацаат бусад өр төлбөр		
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>7,887,659,663.69</b>	<b>7,699,876,900.07</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	109,606,462.97	265,291,438.84
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>109,606,462.97</b>	<b>265,291,438.84</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>7,997,266,126.66</b>	<b>7,965,168,338.91</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	10,238,540,831.48	10,238,540,831.48
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	15,455,050,972.96	15,455,050,972.96
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	709,277,849.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(10,207,566,702.86)	(11,119,263,992.10)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>15,486,025,101.58</b>	<b>15,283,605,661.34</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>23,483,291,228.24</b>	<b>23,248,774,000.25</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>6,135,951,844.69</b>	<b>5,674,443,434.69</b>
2	Борлуулалтын өртөг	7,130,700,395.77	7,937,777,243.05
<b>3</b>	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>(994,748,551.08)</b>	<b>(2,263,333,808.36)</b>
4	Түрээсийн орлого		
8	Бусад орлого	733,892,736.48	2,067,916,382.14
9	Борлуулалт маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	482,788,616.54	612,060,753.92
11	Санхүүгийн зардал	397,740.45	3,593,855.02
12	Бусад зардал	49,027,043.64	100,625,254.08
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(4,749,275.38)	
17	Бусад ашиг ( алдагдал)		
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)</b>	<b>(797,818,490.61)</b>	<b>(911,697,289.24)</b>
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(797,818,490.61)</b>	<b>(911,697,289.24)</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(797,818,490.61)</b>	<b>(911,697,289.24)</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(797,818,490.61)</b>	<b>(911,697,289.24)</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>10,238,540,831.48</b>	<b>15,455,050,972.96</b>	-	<b>(9,409,748,212.25)</b>	<b>16,283,843,592.19</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>10,238,540,831.48</b>	<b>15,455,050,972.96</b>	-	<b>(9,409,748,212.25)</b>	<b>16,283,843,592.19</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(797,818,490.61)	(797,818,490.61)
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>10,238,540,831.48</b>	<b>15,455,050,972.96</b>	-	<b>(10,207,566,702.86)</b>	<b>15,486,025,101.58</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>10,238,540,831.48</b>	<b>15,455,050,972.96</b>	-	<b>(10,207,566,702.86)</b>	<b>15,486,025,101.58</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(911,697,289.24)	(911,697,289.24)
Өмчид гарсан өөрчлөлт			709,277,849.00		709,277,849.00
Бусад дэлгэрэнгүй орлого					-
<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>10,238,540,831.48</b>	<b>15,455,050,972.96</b>	<b>709,277,849.00</b>	<b>(11,119,263,992.10)</b>	<b>15,283,605,661.34</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	2021.12.31	2022.12.31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,570,829,449.96	7,212,917,378.56
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,719,148,540.87	5,777,557,928.56
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	792,716,000.00	1,400,000,000.00
	Бусад мөнгөн орлого	58,964,909.09	35,359,450.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,467,748,782.56	7,338,337,771.17
	Ажиллагчдад төлсөн	2,134,956,022.23	2,303,477,812.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	149,848,705.54	98,989,717.73
	Бараа материал худалдан авахад төлсөн	1,487,348,650.00	1,862,010,201.00
	Ашиглалтын зардалд төлсөн	2,694,415.67	9,480,400.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,060,972,709.79	1,325,614,501.00
	Хүүний төлбөрт төлсөн	1,326,450,816.88	1,475,827,225.94
	Татварын байгууллагад төлсөн	62,081,851.17	74,643,983.49
	Даатгалын төлбөрт төлсөн	190,389,798.83	92,988,337.79
	Бусад мөнгөн зарлага	2,108,800.00	2,108,800.00
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>103,080,667.40</b>	<b>(125,420,392.61)</b>
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		(34,079,600.00)
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-</b>	<b>(34,079,600.00)</b>
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		300,000,000.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		300,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(92,393,537.03)	(144,315,024.13)
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	(92,393,537.03)	(144,315,024.13)
	Төлсөн ногдол ашиг		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(92,393,537.03)</b>	<b>155,684,975.87</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>10,687,130.37</b>	<b>(3,815,016.74)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>(88,704,500.68)</b>	<b>14,376,166.72</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>14,376,166.72</b>	<b>10,561,149.98</b>

## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлт	х.нэгж	2022 оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Сүхбаатар сум	мян.төг	5,649,942.0	5,309,325.0	- 340,617.0	94%
Алтанбулаг	мян.төг	286,013.0	163,855.0	- 122,158.0	57%
Бугант тосгон	мян.төг	284,368.0	201,263.0	- 83,105.0	71%
Эрчим хүчний татаас санхүүжилт	мян.төг	818,181.8	818,181.8	0.0	100%
Бусад орлого	мян.төг	40,358.0	1,249,735.0	1,209,377.0	3097%
<b>Нийт борлуулалтын орлого</b>	<b>мян.төг</b>	<b>7,078,862.8</b>	<b>7,742,359.8</b>	<b>663,497.0</b>	<b>109%</b>
Үйл ажиллагааны зардал	мян.төг	7,186,944.0	7,768,506.0	581,562.0	108%
Элэгдлийн зардал	мян.төг	687,836.0	697,163.0	9,327.0	101%
ҮХ, АТӨЯХАТ	мян.төг	26,367.0	9,255.0	- 17,112.0	35%
Газрын төлбөр	мян.төг	479.0	1,138.0	659.0	238%
Усны нөөц	мян.төг	2,800.0	2,800.0	-	100%
Бусад татвар хураамж	мян.төг	1,200.0	918.0	- 282.0	77%
Ажилчдын нийгмийн зардал	мян.төг	125,900.0	174,277.1	48,377.1	138%
Нийт зардал	мян.төг	8,031,526.0	8,654,057.1	622,531.1	107.8%
<b>Татварын дараах ашиг алдагдал</b>	<b>мян.төг</b>	<b>952,663.2</b>	<b>911,697.3</b>	<b>40,965.9</b>	<b>96%</b>
Нийт төсөвт төлөх татвар	мян.төг			-	
НӨАТ	мян.төг			-	
ААНОАТ	мян.төг			-	
ХХОАТ	мян.төг			-	
Нийт ажиллагсдын тоо	мян.төг	164.0	161.0	- 3.0	98%
Нийт цалингийн сан	мян.төг	2,186,998.0	2,162,170.0	- 24,828.0	99%
Нийт авлага	мян.төг	1,588,484.0	1,452,169.9	- 136,314.1	91%
Нийт өр төлбөр	мян.төг	7,997,266.0	7,965,168.3	- 32,097.7	100%

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь “Орчин үеийн техник технологи нэвтрүүлэн байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл үйлчилгээ явуулж, хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр найдвартай ханган, эдийн засгийн алдагдлыг бууруулах замаар салбартаа тэргүүлэгч байгууллага болно” гэсэн эрхэм зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулааны эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах.
- Гадаад дотоод худалдаа.
- Туслах үйлдвэрлэл хөгжүүлэх.
- Гуанз, цайны газрын үйлчилгээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар”-ын статустай бүртгэгдэж, 100 хувь орон нутгийн өмч эзэмшиж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь аймгийн ИТХ-ын 2002 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 60 дугаар тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь “Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно.”, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Аймгийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна.”, 21.1.15 дахь “харилцаа холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой, / Эрчим хүчний яамнаас олгодог татаас санхүүжилттэй холбоотой /

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн гэх мэт.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь 2013 онд боловсруулагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Уг НБББББ-ийг баталж, хэрэгжүүлж эхэлсэн 2013 оноос хойш холбогдох хууль, эрхийн актууд, стандартад тодорхой хэмжээний нэмэлт, өөрчлөлт орсон байна. Иймээс Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөх, улмаар холбогдох хууль, эрхийн акт, стандартад нийцүүлэн шинэчлэлт хийх шаардлагатай юм.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	14,376.2	10,561.1	-3,815.0
Авлага	1,588,484.1	1,452,169.9	-136,314.2
Татвар, НДШ-ийн авлага	41,411.4	0.0	-41,411.4
Бусад авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	902,057.3	802,886.9	-99,170.4
Үндсэн хөрөнгө	20,936,962.3	20,983,156.1	46,193.8

<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>23,483,291.2</b>	<b>23,248,774.0</b>	<b>-234,517.2</b>
Өр төлбөр	7,997,266.1	7,965,168.3	-32,097.8
Эздийн өмч	15,486,025.1	15,283,605.7	-202,419.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>23,483,291.2</b>	<b>23,248,774.0</b>	<b>234,517.2</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 3,815.0 мянган төгрөгөөр буурсан нь 7,512,917.4 мянган төгрөгийн орлого олж, 7,516,732.4 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 1,452,169.9 мянган төгрөг болж 136,314.2 мянган төгрөгөөр буурсан нь 8,246,666.0 мянган төгрөгийн авлага нэмэгдэж, 8,382,980.2 мянган төгрөгийн авлага буурснаас шалтгаалсан байна.

Татвар НДШ-ийн авлага 41,411.4 мянган төгрөгөөр буурсан нь НДШ-ийн өглөгт суутган тооцох боломжгүйгээс НДШ-ийн зардал дансанд хааснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 802,886.9 мянган төгрөг болж 99,170.4 мянган төгрөгөөр буурсан нь 2,548,936.9 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 2,648,107.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 743,357.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өөрийн хөрөнгөөр 13,970.0 мянган төгрөгийн блокны машин, шавар зуурагч, 5,639.9 мянган төгрөгийн зөөврийн компьютер, принтер, 14,469.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 498 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 149,950.0 мянган төгрөгийн дулааны шугам сүлжээ, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 138,504.4 мянган төгрөгийн дулаан хуваарилах төвийн засвар, шинэчлэлийн ажил, 96,123.4 мянган төгрөгийн дулааны шугам, 185,000.0 мянган төгрөгийн ковш, 139,700.0 мянган төгрөгийн цахилгаан хөдөлгүүр, насос зэрэг хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэснээс шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 7,965,168.3 мянган төгрөг болж 32,097.8 мянган төгрөгөөр буурсан нь дансны өглөг 1,178,412.3 мянган төгрөгөөр буурч, цалингийн өглөг 17,402.7 мянган төгрөгөөр, татварын өглөг 509,845.5 мянган төгрөгөөр, НДШ-ийн өглөг 443,517.4 мянган төгрөгөөр, зээлтэй холбоотой өглөг 175,548.9 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Хуримтлагдсан алдагдал 11,119,264.0 мянган төгрөг болж 911,697.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн алдагдал нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын дарга

нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулсан бөгөөд тайлант оны нийт орлогыг 7,078,863.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 8,031,526.0 мянган төгрөгөөр, алдагдлыг 952,663.0 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 7,742,359.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 8,654,057.1 мянган төгрөгийн зардал гарган, 911,697.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогоос 5,801,733.7 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2022 оны 12-р сарын 28-ны өдрийн А/553 дугаар захирамжаар орон нутгийн төсвөөс 454,545.4 мянган төгрөгийн татаас, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 15,000.0 мянган төгрөг, Эрчим хүчний яамнаас 818,182.8 мянган төгрөгийн татаас санхүүжилт, эрчим хүчний хөнгөлөлтийн орлогоос 745,035.3 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 65,429.5 мянган төгрөг, 157,566.9 мянган төгрөгийн борлуулалтын буцаалт хийж нийт 7,742,359.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Нийт орлогын гүйцэтгэл 7,742,359.8 мянган төгрөг болж төлөвлөгөөг 663,496.8 мянган төгрөг буюу 9.4 хувиар давуулан биелүүлсэн нь эрчим хүчний хөнгөлөлтийн орлого 745,142.8 мянган төгрөг, аймгийн төсвөөс 454,545.4 мянган төгрөгийн татаас олгосноос голлон шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 8,654,057.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 622,531.2 төгрөг буюу 7.8 хувиар хэтэрсэн нь үндсэн үйл ажиллагааны зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд цэвэр алдагдал 911,697.3 мянган төгрөг болж, төлөвлөгөөт алдагдлыг 40,965.7 мянган төгрөгөөр бууруулсан нь нийт орлогыг 9.4 хувиар давуулан биелүүлснээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **4. Аудитын тайлан**

##### **4.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын /цаашид “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ гэх/ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ аудит” ХХК-ийн аудитор Ч.Цэрэннадмид, Т.Эрдэнэтуяа, аудиторын туслах Г.Уранчимэг нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайланг “ЦЭСБ аудит” ХХК-д 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 01/63 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 7,662,912.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 76,629.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.3.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

[www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих 18 төрлийн 159 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 144 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 12 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Үүнд:

1. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлт улиралд оруулах 1 мэдээллийг хугацаа хоцроосон, бүтэн жилээр оруулах 2 мэдээллийг огт шивээгүй.
2. Хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын бүтэн жилээр оруулах 2 мэдээллийг огт шивээгүй.
3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө бүтэн жилээр оруулах 2 мэдээллийг огт шивээгүй.
4. Хөрөнгийн зардал ба хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэл бүтэн жилээр оруулах 2 мэдээллийг огт шивээгүй.
5. Худалдан авах ажиллагааны тайлан бүтэн жилээр оруулах 2 мэдээллийг огт шивээгүй.
6. Аудитын тайлан дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан бүтэн жилээр оруулах 2 огт шивээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

#### **4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд аймгийн ОНӨГ-ын 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 105 тоот албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн үндсэн үйл ажиллагаатай шууд холбоогүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх, тээвэр шатахуун, шуудан холбооны зардлыг хэмнэх, 2021 оны санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн өглөг, авлагыг бууруулах зөвлөмжүүдийг хүргүүлсэн байна. Мөн аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/1696 дугаар албан бичгээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж сум, орон нутгийн төр төсвийн байгууллага, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудыг төсвийн хөрөнгөөр “Шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулахгүй” байх чиглэл хүргүүлсэн байна.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд авлагыг 177,725.6 мянган төгрөгөөр, өр төлбөрийг 32,097.8 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 32 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ.Үүнд:

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь тайлант онд үйл ажиллагааны үр дүнгээр 911,697.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байхад хаврын баярын арга хэмжээнд 6,479.1 мянган төгрөг, цэргийн баярын үйл ажиллагаанд 3,200.0 мянган төгрөг, эрчим хүчний баярын үйл ажиллагаанд 12,838.6 мянган төгрөгийг зэрэг нийт 22,517.7 мянган төгрөгийг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална. 4.1.3 дахь “үр ашигтай байх” гэж заасантай нийцэхгүй байна.

#### **4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

“ЦЭСБ аудит” ХХК-ийн 2022 оны 11 дүгээр 18-ны өдрийн 185 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан,тодруулгад аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус газрын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 349.6 мянган төгрөгийн акт, 41,765.5 мянган төгрөгийн албан шаардлага, 182,411.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	1	349.6	1	349.6	100.0
Албан шаардлага	2	41,765.5	2	41,765.5	100.0
Зөвлөмж	2	182,411.4	2	182,411.4	100.0
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>224,526.5</b>	<b>4</b>	<b>83,151.1</b>	<b>100.0</b>

#### 4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Нийгмийн даатгалын байгууллагад 1,730,006.5 мянган төгрөгийн шимтгэлийн өртэй учраас нийгмийн даатгалын сангаас даатгуулагчид олгох ёстой өмнөх онд хуримтлагдсан 14,494.0 мянган төгрөгийн ХЧТА тэтгэмж, 26,917.4 мянган төгрөгийн жирэмсний болон амаржсаны тэтгэмж, тайлант онд 15,183.4 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж нийт **56,594.8** мянган төгрөгийг Нийгмийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь “Ажил олгогчийн буруугаас нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй даатгуулагчид учирсан хохирлыг ажил олгогч бүрэн хариуцаж төлнө” гэсэн заалтын дагуу байгууллагаас төлсөн нь алдагдлыг энэ хэмжээгээр нэмэгдүүлсэн байна.
- 2022 онд **7,742,359.8** мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого төвлөрүүлж, **8,654,057.2** мянган төгрөгийн зардал гарган, үйл ажиллагааны үр дүнгээр **911,697.3** мянган төгрөгийн алдагдал хүлээсэн, өөрөөр хэлбэл үйл ажиллагаа явуулах тусам алдагдлын хэмжээ нэмэгдэж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр **өөрийгөө санхүүжүүлэх** зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ.....” гэсэн тодорхойлолтыг хангахгүй байгаа учир санхүүгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, зохион байгуулалт, менежментийн өөрчлөлт хийх замаар үйлдвэрлэлийн үр дүнгээр ашиг хүлээх, өөрийгөө санхүүжүүлэх нөөц боломжийг бүрдүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 458 дугаар тогтоолоор хэрэглэгчдэд борлуулах дулааны үнэ тарифыг нэмэгдүүлэхээр баталсан боловч төсвийн байгууллагуудад өр

авлага үүсгэхгүй гэдэг шалтгаанаар төсвийн байгууллагууд мөрдөж ажиллаагүй байна. Энэхүү зөрчилд Эрчим хүчний зохицуулах хорооны улсын ахлах байцаагч аймгийн Засаг даргад 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдөр 60-07-001/29 дүгээр албан шаардлага хүргүүлж, “Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ” нь 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс нэмэгдсэн үнэ тарифаар төсвийн байгууллагад халаалтын үнийг нэхэмжилснээс **970,484.1** мянган төгрөгийн авлага нэмж үүссэнийг өнөөг хүртэл барагдуулаагүй байна. Сумдын боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг болсон тул аймаг, сумдын удирдлагуудад дээрх асуудлыг танилцуулж, үүссэн авлагыг барагдуулах арга хэмжээ авах нь зүйтэй юм.

- 1 тн нүүрсийг / тээврийн зардал орсон / Багануур хувьцаат компаниас 56.1 мянган төгрөгөөр, Техно перспектив компаниас 90.0 мянган төгрөгөөр, Сэлэнгэ тэнгэр хараа компаниас 53.0 мянган төгрөгөөр гэх мэтчилэн харилцан адилгүй үнээр худалдан авч байна. Цаашид дээрх байдалд дүн шинжилгээ хийж, 1 тн нүүрсний өртгийг бууруулах, улмаар үйлдвэрлэлийн зардлыг хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг авах нь зүйтэй юм.

## 5. Аудитын илрүүлэлт

### 5.1 Залруулга

Аудитаар нийт 854,995.3 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Үнэ төлбөргүй хүлээн авсан 709.277.8 мянган төгрөгийн хөрөнгийн дүнгээр төрийн өмчийг нэмэгдүүлснийг эздийн өмчийн бусад хэсгийг нэмэгдүүлж залруулав.
- Аймгийн Засаг даргын захирамжаар олгосон 500,000.0 мянган төгрөг, Эрчим хүчний яамны татаас санхүүжилтээр олгосон 900,000.0 мянган төгрөг, нийт 1,400,000.0 мянган төгрөгийн орлого тайлагнаснаас НӨАТ-ыг суутгалгүйгээр 122,137.8 мянган төгрөгийн борлуулалтын орлогыг илүү тооцсоныг,
- Борлуулалтын орлогыг 122,137.8 мянган төгрөгөөр илүү тайлагнаснаас шалтгаалан НӨАТ-д ногдуулсан өглөгийг 12,213.8 мянган төгрөг илүү тайлагнасан,
- Тушаал шийдвэргүйгээр борлуулалтын 11,365.9 мянган төгрөгийн авлагыг борлуулалтын буцаалтаар бүртгэснийг тус тус залруулав.

Аудитаар нийт **1,653,921.4** мянган төгрөгийн зөрчил илэрч **7,017.4** мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, **1,492,889.4** мянган төгрөгийн албан шаардлага, **154,014.6** мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

## 5.2 Төлбөрийн акт

1. Өглөг, авлагыг хянаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүйгээс өмнөх онд цалингийн урьдчилгааны үлдэгдэлтэй байхад нэмж урьдчилгаа олгосноор эдийн засагч Г.Баатарцогт 4,559.6 мянган төгрөгийн, хүний нөөцийн ажилтан Д.Отгонцэцэг 1,507.8 мянган төгрөгийн, жолооч У.Мөнхбаяр 450.0 мянган төгрөгийн, харуул О.Зоригтбаатар 500.0 мянган төгрөгийн зэрэг нийт **7,017.4** мянган төгрөгийн он дамжсан цалингийн урьдчилгааны авлагын үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Он дамжсан цалингийн урьдчилгааг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

## 5.3 Албан шаардлага

1. 2022 оны санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслэн тооцож, төлөвлөн аймгийн Засаг даргаар батлуулаагүйгээс урсгал засварын зардлыг 132,930.0 мянган төгрөгөөр, нүүрс болон нүүрсний тээврийн зардлыг 235,673.0 мянган төгрөгөөр, сэлбэг хэрэгслийн зардлыг 66,694.0 мянган төгрөгөөр, байгууллагаас төлөх НДШ-ийн зардлыг 132,430.0 мянган төгрөгөөр, ашиглалтын зардлыг 186,686.0 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 4,229.0 мянган төгрөгөөр, хөдөлмөр хамгааллын зардлыг 26,693.0 мянган төгрөгөөр, бусад зардлыг 116,762.0 мянган төгрөгөөр зэрэг нийт **902,097.0** мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.3 дахь *“Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан **биелэлтийг хангах**”* гэсэн заалт болон аймгийн Засаг даргын баталсан “Сэлэнгэ Энерго ” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн орлого, зарлагын нэгдсэн төлөвлөгөө”-г зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тухайн жилийн санхүүгийн орлого, зарлагын нэгдсэн төлөвлөгөөг тооцоо судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөж, мөрдөн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Тайлант оны 10, 11, 12 сард нярав Д.Цэндсүрэнд тушаал шийдвэргүйгээр буюу анхан шатны баримтын бүрдэлгүйгээр **1,218.1** төгрөгийн илүү цагийн хөлс бодож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”* 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бзүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэн бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

3. Тус үйлдвэрийн газар нь тайлант онд үйл ажиллагааны үр дүнгээр 911,697.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байхад хаврын баярын арга хэмжээнд 6,479.1 мянган төгрөг, цэргийн баярын үйл ажиллагаанд 3,200.0 мянган төгрөг, эрчим хүчний баярын үйл ажиллагаанд 12,838.6 мянган төгрөгийг зэрэг нийт **22,517.7** мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх “*Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална. 4.1.3 дахь “үр ашигтай байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.*

**Шийдвэрлэсэн нь:** Хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4. Санхүүгийн тайланд тусгагдсан өр, авлагыг тулган баталгаажуулахад тооцоо нийлсэн актаас “Сэлэнгэ Цэнгэг ус” ОНӨААТҮГ-т төлөх өглөгийг **6,212.7** мянган төгрөгөөр дутуу, Төрийн банканд төлөх зээлийн өглөгийг **6,590.7** мянган төгрөгөөр илүү, НӨАТ-ын өглөгийг **554,253.2** мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 20.2.6-д “*... тооцоо нийлж үлдээгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах*”, гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** 2023 оны эхний хагас жилд багтаан тооцоо нийлж, залруулж бүртгэх албан шаардлага хүргүүлэх.

#### **5.4 Зөвлөмж**

##### ***Татвартай холбоотой асуудал***

**1.1 Илрүүлэлт:** Тайлант онд борлуулалтын орлогыг харилцагч тус бүрээр бус бөөн дүнгээр шивсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “*...байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь ...хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна*” гэж заасныг зөрчсөн байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Борлуулалтын орлогыг харилцагч нэг бүрээр тухай бүр бүртгэж байх.

##### ***Шатахуун зарцуулалттай холбоотой асуудал:***

**2.1. Илрүүлэлт:** Олон жил ашиглагдаж байгаа хуучин авто машинуудын шатахууны зарцуулалтад ажиглалт хийж норм, нормативыг шинэчлэн тогтоогоогүйгээс нүүрс түрэгч гинжит тракторын шатахууныг жишиг нормоос илүү тооцон 1250 литр буюу **5,737.5** мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 1.3 дахь заалтыг зөрчсөн байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:** Автомашины шатахуун зарцуулалтад ажиглалт хийж, нормыг шинэчлэн тогтоож, хэрэгжүүлэх.

## Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

**3.1 Илрүүлэлт:** Тайлант онд **148,277.1** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

**3.2 Өгсөн зөвлөмж:** Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Залруулсан			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эзний өмчийг нэмэгдүүлснийг эзний өмчийн бусад хэсгээр залруулав.	1	709,277.8			1	709,277.8	1	709,277.8				
Борлуулалтын орлогыг илүү тооцсон.	1	122,137.8			1	122,137.8	1	122,137.8				
Авлагаар бүртгэж залруулсан	1	11,365.9			1	11,365.9	1	11,365.9				
НӨАТ-ын өглөг илүү тайлагнасныг залруулав.	1	12,213.8			1	12,213.8	1	12,213.8				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>854,995.3</b>			<b>4</b>	<b>854,995.3</b>	<b>4</b>	<b>854,995.3</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн урьдчилгаа суутгагүй.	1	7,017.4	1	7,017.4								
Анхан шатны баримтгүйгээр илүү цагийн нэмэгдэл олголсон	1	1,218.1			1	1,218.1						
Төлөвлөгөөг хэтрүүлэн зарцуулсан	1	902,097.0			1	902,097.0						
Үр ашиггүй зардлыг санхүүжүүлсэн	1	22,517.7			1	22,517.7						
Өглөгийг зөрүүтэй илэрхийлсэн	1	567,056.6			1	567,056.6						
Шатахууны зарцуулалтад ажиглалт хийж нормыг тогтоогоогүй	1	5,737.5					1	5,737.5				
Борлуултын орлогыг харилцагч нэг бүрээр бус бөөн дүнгээр бүртгэсэн	1						1					
Цахим төлбөрийн баримт шивэгдээгүй.	1	148,277.1					1	148,277.1				
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>1,653,921.4</b>	<b>1</b>	<b>7,017.4</b>	<b>4</b>	<b>1,492,889.4</b>	<b>3</b>	<b>154,014.6</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
мэдээлэл хугацаа хоцроосон	1				1			
мэдээллийг огт мэдээлээгүй	12				12			
<b>Дүн</b>	<b>13</b>				<b>13</b>			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>13</b>				<b>13</b>			